



ТАХЬ АДУУ

Przewalski's horse (Takhi)

*Equus
ferus przewalskii*

Groves, 1986

Ангилал зүй / Taxonomy

Хүрээ: Хөвчтөн /Phylum: Chordata

Анги: Хөхтөн /Class: Mammalia

Баг: Битүү туурайтан /Order: Perissodactyla

Овог: Адууныхан /Family: Equidae

Төрөл: Адүү /Genus: Equus

Таних шинж Биеийн урт 220-280 см, мундааны өндөр 115-146 см, биеийн жин 275-325 кг хүрнэ. Бие лагс, толгой том, хүзүү бахим, цээж өргөн, сэрвээ, хондлой тэнцүү. Дэл босоо, ихэвчлэн голоороо хар өнгөтэй. Сүүл шингэн, хялгастай

Characteristics: Body length 220-280 cm, shoulder height 115-146 cm, body weight 275-375 kg. Stocky body, large head, wide chest, stubby neck. Mane is short, upright and black in the middle. Tail base is flat with short hair, length 92-111 cm. Light sandy to dark brown body coloration, normally white abdomen and white nose. Fur darker and longer in winter. Dark dorsal stripe from mane to tail. Lower parts of legs dark, often striped.

сүүлний урт 92-111 см. Зүс нь голдуу хул хонгор боловч улирлаас хамааран өөрчлөгднө. Хэвлүй, цавь, суга, гуяны зураа орчим цайвар зүстэй, мундаанаас зоо нуруу дагуу сүүлний цааг хялгас хүртэл хар бор туш хүрэн судалтай (хар голтой). Борвиноос доош бараавтар байх боловч олонхи бодгаль нь шилбэ, өвдөгний ар тал, борвиндоо хөндлөн хар судалтай.

Статус Монгол улсын амьтны тухай хууль – Нэн ховор амьтан, Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – Устаж байгаа зүйл, байгаль дээр устсан зүйл, Зүүнгарын говь – Уугуул амьтан.

Status: Mongolian animal law – Very rare animal. IUCN Red list Globally and Regionally – Endangered (EN), previously Extinct in the Wild (EW), Dzungarian Gobi – Native species.

Амьдралын онцлог Сүргээр амьдарна, өвлүүн цагаар арай том сүрэг болон нийлж бэлчдэг. Нэг сүрэг дунджаар 5-10 бодгалттай. Хавар, зун, намар говийн задгай ус, булаг, шанднаас, өвөлдөө цасаар ундаална. Усанд өдөр бүр, хааяа өнжөөд ирнэ. Ороо нийллэгт 6-8 дугаар сард орж, дараа оны 5-7 дугаар сард унагална. Байдас 2-3, үрээ 3-5 настайгаасаа үргжилд орно.

Habits and breeding: Lives in harems, but can gather into larger herds in winter. A typical harem consists of 5-10 individuals. During spring, summer, and autumn drinks from open water sources. During winter gets its water supply from snow. Needs to drink daily or every second day. Mates from June until August. Foals are born between May and July. Females become sexually mature between the ages of 2 and 3 years and males between the ages of 3 and 5 years.

Амьдрах орчин Говь, цэлийн заг, тэсэг, шаваг, баглуур, бударгана, хялгана бүхий намхан уулс, толгод тэдгээрийн хоорондох хотос, хоолой, тал хөндий, баянбурдүүдэд идээшилнэ. Монголд Говийн их дархан цаазат газрын "Б"хэсэг (1992), Хустайн нуруу (1992 он), Хомын тал (2004 он)-ын байгалийн цогцолбор газарт тус тус сэргээн нутагшуулж байна.

Habitat: Steppe or semi-desert. In Mongolia, takhi were reintroduced to the Great Gobi B Strictly Protected Area (1992), Hustai National Park (1992), and Khomyn tal (2004).

ЦООХОР ИРВЭС

Snow leopard (Irbis)



Таних шинж Урт сунасан биетэй, харьцангуй богино хөлтэй, урт сүүлтэй. Биеийн урт 110-130 см, сүүлний урт 80-105 см, чихний урт 6.6-7.2 см, сэрвээний өндөр 60 см, биеийн жин 22-55 кг хүрнэ. Толгой жижиг, чих богино. Муурын овгоос

Panthera uncia
Schreber, 1775
Ангилал зүй / Taxonomy

Хүрээ: Хөвчтөн / Phylum: Chordata
Анги: Хөхтөн / Class: Mammalia
Баг: Mach ideshetgen / Order: Carnivora
Овог: Мийнхэн / Family: Felidae
Төрөл: Ирвэс / Genus: Panthera

Characteristics: Long slender body with short legs and a long tail. Body length 110 -135 cm, tail 80-105 cm, ear length 6.6-7.2 cm, shoulder height up to 60 cm and weight 22-55 kg. Head is small and ears are short. The biggest wild cat species in Mongolia. Body is tan or grey with large black spots of 6 to 8 cm. Belly is white. Tail is almost as long as the body and has thick hair. Feet are big and strong.

хамгийн том биетэй төлөөлөгч. Зүс боровтор эсвэл шаргал туяатай саарал, 6-8 см дугуйтар хар толбонуудтай эрээн цоохор зүстэй, хэвлэлий орчим цайвар өнгөтэй. Сүүл нь биеийн урттай бараг тэнцүү. Сүүл урт, өтгөн үстэй. Тавхай хүчирхэг, том.

Статус Монгол улсын амьтны тухай хууль – Нэн ховор амьтан, Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – Эмзэг зүйл.
Status: Mongolian animal law - Very rare animal., IUCN Red List Globally - Vulnerable (VU).

Амьдралын онцлог Гол төлөв бүрэнхий, шөнийн идэвхтэй. Өөрийн эзэмшил нутгаа тэмдэглэнэ. Янгир, тарвага, огодой, туулай, хар сүүлтий, адuu, хонь, ямаа, хахилаг, хойлгоор хооллоно. Заримдаа хулан, аргаль зэрэг тураг амьтдыг ч барьж иднэ. Эм ирвэс хадны агуй, хонгил, ангалд үүрлэнэ. Ороо нийллэг 1-3 дугаар сард болно. Хээл тээх хугацаа дунджаар 98-104 хоног. Эм ирвэс 2-3 гүем төрүүлнэ. Хоёр, гурван настайдаа үргжилд орж эхэлдэг бөгөөд байгальд 15-18 жил насална.

Habits and breeding: Active at twilight and nocturnally. Individuals mark their territory with scent and scrape marks. Feeds on ibex, marmots, picas, hare, goitered gazelle, livestock and some birds, sometimes catching large animals such as wild ass and argali. Females hide their small young in rocky caves, natural tunnels and abysses. Mates in January to March. Gestation period 98-104 days and 2-3 cubs are born. Becomes sexually mature at 2-3 years old. Life span 15-18 years.

Амьдрах орчин Ирвэс 2500-3500 м өндөр уулсын гүн хавцал жалга, хад цохиот эгц хажуу зэрэг гөрөөс амьтдыг отож, довтлох боломжтой бартаат газрыг түлхүү сонгож байрладаг. Мөн говь, цөлийн хад чулуут уулс, баянбурдэд амьдарна. ГИДЦГ-ын “Б” хэсгийн Хөвчийн нуруу, Өвөр хад, Тахийн шар нуруу, Тахийн Хөх өндөр, Хавтаг, Байтагийн уулс, Алагхайрхан уулын БНГ ирвэстэй.

Нэршил: Монголчууд ирвэсийн эрийг гэнд, эмийг гинс, нялх төлийг гүем хэмээн нэрлэдэг.

Habitat: Mountainous areas at an altitude of 2500 to 3500 m, prefers steep rocky slopes where it uses the natural cover to stalk its prey. Also living in rocky mountain ranges and oasis in the Gobi. Can be found in Khovchiin nуruu, Uvur khad, Takhii shar nуruu, Takhii huh undur, Khavtag, Baitag mountains of Great Gobi B Strictly Protected Area and Alaghaikhan Mountain Nature Reserve.



ЗҮҮНГАРЫН ДААХАЙ

Mongolian three-toed jerboa

*Styloctopus
sungorus*

Sokolov and Shenbrot, 1987
Ангилал зүй / Taxonomy

Хүрээ: Хөвчтөн / Phylum: Chordata

Анги: Хөхтөн / Class: Mammalia

Баг: Мэрэгчтэн / Order: Rodentia

Овог: Алагдаагынхан / Family: Dipodidae

Төрөл: Даахай / Genus: Styloctopus

Таних шинж Биеийн урт 125-130 мм, сүүлний урт 150-165 мм, хойт тавхайн урт 54-58 мм, биеийн жин 85-90 гр. Биеийн нуруун тал бараавтар долгио бүхий элсэн саарал өнгөтэй бөгөөд ийм өнгө нь биеийн хойд хэсэгт илүү тодорхой ажиглагдана.

Characteristics: Body length 125-130 mm, tail length 150-165 mm, hind foot length 54-58 mm. Body weight 85-90 g. Grey fur with brown fur tips making it appear sandy and wavy. This feature is especially noticeable on the back of the body. White abdomen. Upper side of tail is greyish yellow. Tail flag is ash grey. Upper side of the hind feet is covered with short white hairs, lower side has black-brown hairs. White spots on the back of ears and stripes on the thighs are important identification signs.

Хэвлүй цагаан, нурууны өнгөнөөс сүүлний дээд тал нь илүү тод, сааралдуу шаргал. Сүүлний үзүүрийн цацаг үнсэн саарал өнгөтэй. Хойт тавхайн дээд тал нь цагаан өнгийн богино үстэй, доод тал нь хар бор өнгийн үстэй. Чихний арын цагаан толбонууд, гуяны цагаан зурсас зэрэг нь даахайг таних чухал шинж тэмдэг юм.

Статус Монгол улсын амьтны тухай хууль – Нэн ховор амьтан, Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – анхааралд өртөхөөргүй зүйл, Зүүнгарын говь – Унаган зүйл.

Status: Mongolian animal law – Very rare animal. IUCN Red List - Globally Least Concern (LC), Dzungarian Gobi – Endemic species.

Амьдралын онцлог Шөнийн идэвхтэй. Говийн элсэрхэг болон шаварлаг хөрсөнд нэлээд гүнд 5-6 м орчим урттай нүх ухаж орогоно. Зун, намрын улиралд үрээр хооллоно. Өвөл ичнэ. Идэш тэжээлийн зонхилох хэсгийг ургамлын үр, шавж эзэлнэ. Жилд нэг удаа төллөх бөгөөд 3-4 зулзага төрүүлнэ.

Habits and breeding: Nocturnal. Digs a burrow about 5-6 m in length in sandy and clayey soils of the Gobi. Feeds on seeds during summer and autumn. Hibernates during winter. Feeds mostly on seeds and insects. Produces a litter of 3-4 young once a year.

Амьдрах орчин Элсэрхэг хөрстэй, сийрэг ургамалтай хуурай цөлд байршин амьдарна. ГИДЦГ-ын “Б” хэсгийн говь, цөлд нэлэнхүй тархалттай.

Habitat: Lives in dry desert habitats with sandy soil and sparse vegetation. It is common in the Gobi and desert part of Great Gobi B Strictly Protected Area.

СУХАЙН ЧИЧҮҮЛ

Tamarisk jerbil



Merioness

tamariscinus

Pallas, 1773

Ангилал зүй / Taxonomy

Хүрээ: Хөвчтөн / Phylum: Chordata

Анги: Хөхтөн / Class: Mammalia

Баг: Мөрэгчтэн / Order: Rodentia

Овог: Чичүүлийнхэн / Family: Gerbillidae

Төрөл: Чичүүл / Genus: Merioness

Таних шинж Зоо нуруу, хажуу талаар бор шаргал, хул хонгор, хэвлүй цагаан. Сүүлний дээд, доод талын өнгө эрс ялгарна. Сүүлний төгсгөл хэсгийн үс уртасч “бийр” маягийн цацаг үүсгэнэ. Тавхайдаа бараан үстэй. Нүднийхээ дээр тод цагаан

Characteristics: Back and flanks yellowish or reddish brown, abdomen white. High color contrast between upper and lower sides of tail. Long hairs at tail tip form a tassel. Hind feet have dark hairs. White spot over each eye. One of the larger bodied species of gerbil. Body length 180 mm, tail length 160 mm and body weight 160 g.

толботой. Төрөл дотроо том биетэй зүйлд хамаарах ба биетийн урт 180 мм, сүүл 160 мм, жин 160 гр хурнэ.

Статус Монгол улсын амьтны тухай хууль – Нэн ховор амьтан, Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – Олон улсын хэмжээнд - Анхааралд өртөхөөргүй зүйл, Зүүнгарын говь – Унаган зүйл.

Status: Mongolian animal law – Very rare animal. IUCN Red List Globally – Least Concern (LC), Dzungarian Gobi – Endemic species (easternmost edge of distribution range).

Амьдралын онцлог Өвөл өдрийн, зун шөнийн идэвхтэй. Зун говийн ургамлын шүүслэг хэсгээр, бусад улиралд үндэс, иш, үр навч, сөөгний холтос, өвслөг ургамлаар хооллоно. Үржлийн үе хавар 3, 4-р сараас намар 9-р сар хүртэл үргэлжилнэ. Жилд 2-3 удаа төрөх ба нэг удаад 4-7 бөлбөөхий гаргана. Бусад оронд таримал ургамлын “хортон” гэгдэж, зарим өвчний халдвартыг тээж дамжуулдаг.

Habits and breeding: Diurnal in winter and nocturnal in summer. During warm season feeds on succulent parts of plants. Also eats roots, stem, leaves and seeds. Mating starts in March-April and continues until September. Produces a litter of 4-7 young 2-3 times a year. In other countries considered “pests” and known to transmit diseases.

Амьдрах орчин Жинхэнэ говийн амьтан. Шаварлаг дагжуур хөрстэй газар бараадах ба сул элснээс зайлсхийнэ. Баянбурд, хужир мараат хонхор, хотсын захаар заг, сухай ургасан элсэн довцогт голдуу байршина. Мод бутны доогуур олон амсартай нийлмэл зохион байгуулалттай нүх ухаж орогоно. Одоогийн байдлаар ГИДЦГ-ын “Б” хэсгийн Тахь ус, Ёлхонд тэмдэглэгджээ.

Habitat: True representative of the Gobi. Prefers hard soil, avoids areas of loose sand. Lives in sandy dunes with tamarisk and saxaul around oases and salt marshes. Digs multilayered, complex burrows with many entrances under trees and bushes. Occurs only in Great Gobi B Strictly Protected Area where they have been recorded in Takhi Us and Yolkhon.

ДАВЖАА АЛАГДААГА

Small five-toed jerboa



Allactaga elater

Lichtenstein, 1828

Ангилал зүй / Taxonomy

Хүрээ: Хөвчтөн / Phylum: Chordata

Анги: Хөхтөн / Class: Mammalia

Баг: Мэрэгчтэн / Order: Rodentia

Овог: Алагдаагынхан / Family: Dipodidae

Төрөл: Алагдаараа / Genus: Allactaga

Таних шинж Биеийн гадаад төрхөөрөө бусад алагдаагатай төстэй боловч биеэр жижиг харагдана. Биеийн урт 95-115 мм, сүүлний урт 144-185 мм, тавхайн урт 60 мм-ээс бага, чихний урт 29-43 мм, биеийн жин 32-77 гр. Нуруун тал нь

Characteristics: Similar to other jerboas but slightly smaller. Body length 95-115 mm, tail length 144-185 mm, hind foot length less than 60 mm, ear length 29-43 mm and body weight 32-77 g. The back has a brownish sandy yellow. It differs from other jerboas in the absence of white hair in the bushy tip of its tail.

боровтор элсэн шаргал өнгөтэй. Сүүлний цацагны хар үсний урд цагаан өнгийн үс байхгүйгээрээ бусад алагдааганаас ялгагдана.

Статус Монгол улсын амьтны тухай хууль – Нэн ховор амьтан, Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – Олон улсын хэмжээнд Анхааралд өртөхөөргүй зүйл, Зүүнгарын говь – Унаган зүйл.

Status: Mongolian animal law – Very rare animal. IUCN Red List Globally – Least Concern (LC), Dzungarian Gobi – Endemic species (easternmost part of the range).

Амьдралын онцлог Нэг амсартай нүхний урт 1-1.5 м, өдрийн цагаар нүхээ бөглөдөг. Ургамлын ногоон хэсэг, үр болон сонгинолог булцуугаар хооллоно. Жилд 1-2 удаа төрөхдөө 2-8 зулзага гаргадаг.

Habits and breeding: Digs burrow 1-1.5 m in length and seals the entrances in day time. Feeds on green parts of plants, seeds and onion tubers. Produces a litter of 2-8 young 1-2 times a year.

Амьдрах орчин Цэл болон заримдаг цэлийн бүсэд заг, зээргэнэ, харгана ургасан наанги шаварлаг хөрстэй чuluурхаг газарт байршина. Ургэлжилсэн их элс болон ургамалгүй шал, тойрмоос зайлсхийнэ. Зөвхөн ГИДЦГ-ын “Б” хэсэгт ховорхон үзэгдэнэ.

Habitat: Stony desert with muddy soil types. Avoids large, continuous stretches of sand and barren drylands without plant cover. Rarely seen, in Mongolia found only in the Great Gobi B Strictly Protected Area.

ХАР СҮҮЛТИЙ

Goitered gazelle



Таних шинж Биеийн урт 110-116 см, сэрвээний өндөр 64-75 см, сүүлний урт 16-20 см, чихний урт 8-13 см, биеийн жин 18-33 кг. Сүүлний үзүүр хар, зөвхөн манхим 25-41 см урт эвэртэй. Тангийн дээд зах сүүлний уг хүрнэ. Зүс нь улирлаар өөрчлөгдөх

*Gazella
subgutturosa*

Güldenstädt, 1780

Ангилал зүй / Taxonomy

Хүрээ: Хөвчтөн / Phylum: Chordata

Анги: Хөхтөн / Class: Mammalia

Баг: Салаа туурайтан / Order: Artiodactyla

Овог: Тугалмайтан / Family: Bovidae

Төрөл: Зээр / Genus: Gazella

Characteristics: Body length 110-116 cm, shoulder height 64-75 cm, tail length 16-20 cm, ear length 8-13 cm, and body weight 18-33 kg. The tip of the tail is black. Only the male gazelle has 25-41 cm long horns. Both sexes have a white rump. The color changes seasonally from a reddish brown back and white belly in summer to a tan-colored back in winter.

ба зунд улаавтар шаргал, цайвар, өвөлдөө цайвар шаргал өнгөтэй.

Статус Засгийн газрын тогтоол – Ховор амьтан, Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – Эмзэг зүйл

Status: Government resolution – Rare animal, IUCN Red list – Globally and Regionally Vulnerable (VU).

Амьдралын онцлог Сүрэглэн амьдарна, хааяа ганц нэгээр үзэгдэнэ. Намар, өвлийн адаг, хаврын эхэн саруудад зуу гаруй тоотой сүргүүд элбэг тохиолдоно. Ихэвчлэн өглөө, оройд идэвхтэй, өвөлд өдөржин идээшилнэ. Элдэв зүйлийн өвслөг ургамал иднэ. Улирлын байдлаас хамаарч нүүдэллэдэг. Ороо хөөцөө 12, 1-р сард болно. Хээл тээх хугацаа 180 хоног. Шаргачин 5-6 сард төллөнө. Зүүнгарын говьд ихэр янзага төрүүлэх нь элбэг. Хоёр настайдаа үржилд орно. Байгалийн нөхцөлд 6-7 жил насална.

Habits and breeding: Lives in small herds and occasionally can be seen alone. During autumn, late winter and early spring can aggregate to large herds of more than 100. Active mainly in the morning and evening in summer, but grazes in winter throughout the day. Feeds on different plant species. Migrates seasonally. Mates in December and January. Gestation period 180 days. Gives birth during May and June. Twins are common in the Dzungarian Gobi. Mates first when 2 years old. Life span 6-7 years.

Амьдрах орчин Монгол орны цөлөрхөг хээр, цөлийн бутлаг, өвслөг ургамал бүхий аараг, уул толгод, дэнж, тал хөндий дагаж байршина. ГИДЦГ-ын “Б” хэсгийн говь цөл, баянбүрд, нам өндөртэй уул толгодод нэлэнхүй тархалттай.

Habitat: Lives in semi-desert and desert areas with grass or shrubby vegetation throughout southern Mongolia. Can be found throughout the plains, at oases and in small mountainous areas of Great Gobi B Strictly Protected Area.

МОНГОЛ ХУЛАН

Asiatic wild ass or khulan



Equus hemionus

Pallas, 1775

Ангилал зүй / Taxonomy

Таних шинж Мөч чацархаг, толгой данхар мөн урт чихтэй. Улирал болон бодгалиас хамаарч ухаа хонгор, цайвар хул, бор, бор хул зүстэй ч тохиолдоно. Хэвлүй, цавь, суга, гуяны зураа орчим цайвар үстэй. Мундаанаас зоо нуруу дагуу сүүлний цацаг хялгас хүртэл бор тууш хүрэн судалтай (хар голтой). Дэл босоо,

Хүрээ: Хөвчтөн / Phylum: Chordata

Анги: Хөхтөн / Class: Mammalia

Баг: Битүү туурайтан / Order: Perissodactyla

Овог: Адууныхан / Family: Equidae

Төрөл: Адуу / Genus: Equus

Characteristics: Long legs and ears, large heavy head. Color tan to light brown, depending on season and individual. Dark brown dorsal stripe from mane to tail. Normally white belly and thighs. Short, erect dark mane with no forelock. Tail tip has long black hairs. Body length 200-260 cm, height at withers 110-140 cm, ear length 17.5-26.5 cm and body weight 200-300 kg. Skull differs from domestic horse and Przewalski's horse by presence of a protuberance in the upper jaw.

ахар, хар өнгөтэй, хөхөлгүй, сүүлний годонгийн төгсгөлд хар бараан цацаг хялгастай. Биеийн урт 200-260 см, мундаа орчим чац нь 110-140 см, чихний урт 17.5-26.5 см, биеийн жин 200-300 кг хүрнэ. Хуланг толгойн ясаар нь тахь, адуунаас хялбар ялгах гол шинж нь дээд эрүүний завсарын ясны нийлэх хэсэгт байрлах товтор юм.

Статус Засгийн газрын тогтоол – Ховор амьттан, Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – Устаж болзошгүй.

Status: Government resolution – Rare animal, IUCN Red List – Near Threatened (NT).

Амьдралын онцлог Ороо нийллэг 7, 8-р сард тохиож дараа оны 6, 7-р сард нэг унага төрүүлнэ. Хээлээ 340 орчим хоног тээнэ. Байдас 3-4, үрээ 4-5 нас хүрч үргжилд орно. Зун өглөө, орой, шөнийн цагаар, сэргүүн улиралд өдрийн турш идээшилнэ. Үржлийн үед азарга гүүгээ хурааж бусдаас тусгаарлахыг эрхэмлэнэ. Ихэвчлэн 3-5 бодгалттай жижиг сүрэг үүсгэх боловч сэргүүн улиралд 100-1000 хүртэл бодгалиудтай том сүрэг бүрэлдэнэ. Дунджаар 14 насалдаг боловч 20-иос дээш жил амьдрах нь элбэг. ГИДЦГ-ЫН “Б” хэсэгт 29 настай толгойн яс олдсон.

Habits and breeding: Mating time from July to early August. Foals are born from June to July. Gestation period around 340 days. Females become sexually mature between the ages of 3 and 4 years and males between the age of 4 and 5 years. In summer grazes during morning, evening and night. During the cold season grazes throughout the day. During the mating season stallions try to isolate the mares from the others. Most often found in small groups of 3-5, but can aggregate and form large herds up to 100s or 1000s of individuals. Average life span around 14 years, but may live for over 20 years. In Great Gobi B Strictly Protected Area the skull of a 29 year old khulan was fund.

Амьдрах орчин Цэл, цөлөрхөг хээрийн заг, баглуур бударгана, өдлөг хялгана хөмүүлт бэсрэг уулсын бэл, хөндий, нам аараг, толгод, уудам хотос, хоолой, сайр, садарга, талбай дэнжээр идээшилнэ. Задгай булаг, шанд, тойром шүтэх авч, задгай усгүй нутагт сайранд татаал гаргаж ундаална. Ус, нутаг дагаж, байнга шилжик хөдөлдөг. ГИДЦГ-ЫН “Б” хэсэгт хулан элбэг тааралдана.

Habitat: Lives in dry desert and semi-desert habitats. Prefers open plains. Regularly visits springs and ponds to drink. Can also dig for water in dry riverbeds where subsurface flow exists. Always migrates between water and pasture. Most commonly seeing in Great Gobi B Strictly Protected Area.

АРГАЛЬ ХОНЬ

Argali



Ovis ammon

Linaeus, 1758

Ангилал зүй / Taxonomy

Хүрээ: Хөвчтөн / Phylum: Chordata

Анги: Хөхтөн / Class: Mammalia

Баг: Салаа туруутан / Order: Artiodactyla

Овог: Тугалмайтан / Family: Bovidae

Төрөл: Хонь / Genus: Ovis

Таних шинж Лагс том биетэй, хөл харьцангуй урт. Биеийн урт 140-150 см, сэрвээний өндөр 120-125 см. Угалз, хомь хоёулаа эвэртэй. Угалзын эвэр мушгирсан хэлбэртэй бөгөөд урт нь 58-150 см, хааяа 170 см хүрнэ. Түүний эврийн уг хэсгийн

Characteristics: Stocky and heavy body, relatively long legs. Body length 140-150 cm, shoulder height 120-125 cm. Both males and females have horns. The male's horns are curved, length 58-150 cm, sometimes up to 170 cm. Horn base circumference 40-44 cm. The female's horns are smaller, 25-35 cm. Males weigh 40-200 kg, females 27-76 kg. Grey-brown body coloration in summer, lighter in winter.

тойрог 40-44 см. Хомийн эвэр жижиг, 25-35 см урт, мушгиа багатай. Угалз 40-200 кг, хомь 27-66 кг жинтэй. Зуны зус хүрэвтээр бор, цайвар. Харин өвлийн зүс цайвар.

Статус Засгийн газрын тогтоол – Ховор амьтан, Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – Устаж болзошгүй.

Status: Government resolution – Rare animal, IUCN Red List – Near Threatened (NT).

Амьдралын онцлог Сүргээр амьдарна. Намар, өвөлд олноороо сүрэглэнэ. Зуны өглөө, орой, өвөлд өдөржин идээшилнэ. Элдэв зүйлийн өвслөг ургамлууд, үет ургамал голдуу иднэ. Өвөлд сөөглөг ургамлын мөчир иднэ. Ус, ургамлын нөөцөөс хамааран улирлаар нутаг сэлгэнэ. Ороо хөөцөөнд 10-р сард орно. Хээл тээх хугацаа 150 хоног. Жилд 1 удаа төллөх ба ихэвчлэн нэг, хааяа ихэрлэнэ. Аргаль хонь 2-3 нас хүрч үргжилд орж, байгалийн нөхцөлд 10-18 жил насална.

Habits and breeding: Lives in herds. Herds become larger in autumn and winter. Active in the morning and evening, grazes in winter throughout the day. Feeds on different plant species. In winter feeds on shrubs. Migrates seasonally. Mates in October. Gestation period about 150 days. Normally produces one young, occasionally twins. Become sexually mature at 2-3 years. Life span 10-18 years.

Амьдрах орчин Монгол орны уулархаг нутгийн хад асгат налуу, тагийн бүсийн дэвсэгт байршин амьдарна. ГИДЦГ-ын “Б” хэсгийн Тахийн шар нуруу, Хавтаг, Байтагийн уулсад нэлэнхүй тархалттай ба заримдаа загт хоолойд гүйдлийн аргаль үзэгдэнэ.

Habitat: Mountain plateaus, rocky outcrops and hilly areas in Mongolia. Prefers less rugged areas than ibex. Can be found in Takhiin Shar Nuruu, Khavtag and Baitag mountain in Great Gobi B Strictly Protected Area. Sometimes seen in places with saxaul.

ЯНГИР ЯМАА

Siberian Ibex



Таних шинж Хүнд лагс биетэй, хөл богино, сахал урт, эвэр хүнд. Биеийн урт 130-165 см, сэрвээгээрээ 70-110 см, сүүлний урт 10-18 см, чихний урт 14-16 см. Тэх 74-139 см, ямаа 16-38 см урт эвэртэй. Тэхийн биеийн жин 45-153 кг, ямааных 29-

Capra sibirica

Pallas, 1776

Ангилал зүй /Taxonomy

Хүрээ: Хөвчтөн / Phylum: Chordata

Анги: Хөхтөн / Class: Mammalia

Баг: Салаа туруутан / Order: Artiodactyla

Овог: Тугалмайтан / Family: Bovidae

Төрөл: Ямаа / Genus: Capra

Characteristics: Large body, short legs, long beards, heavy horns. Body length 130-165 cm, shoulder height 70-110 cm, tail length 10-18 cm, ear length 14-16 cm. Weight male 45-153 kg and female 29-90 kg. Condyle-basal length male 26-31 cm and female 23-26 cm. Body coloration of young individuals red, black brown, lighter with age.

90 кг. Тэхийн толгойн ясны (кондилобазаль) урт 26-31 см, ямааных 23-26 см. Залуу бодгаль ихэвчлэн улаавтар, хар хүрэн, хар халтар, хөгшрөх үедээ цайвар халтар зүстэй болно.

Статус Засгийн газрын тогтоол – Ховор амьтан, Дэлхийн байгаль хамгаалах холбоо-ны улаан данс – Устаж болзошгүй.

Status: Government resolution - Rare animal. IUCN Red List – Near Threatened (NT).

Амьдралын онцлог Өндөр ууланд 3-40 тоо толгойгоор сүрэглэн амьдарна. Намар, өвөлд олноороо сүрэглэнэ. Зун өглөө оройд, өвөлд өдөржин идээшилнэ. Элдэв зүйлийн өвслөг ургамал иднэ. Идэш тэжээлд үетэн, сонгинын төрөл, бут сөөгний навь зонхицно. Ороо хөөцөлдөөн 11-р сарын сүүлч, 12-р сарын эхээр орно. Хээл тээх хугацаа 140-175 хоног. Ямаа 4-р сарын сүүлчээр нэг, хааяа ихэвчлийн гаргана. Хөхүүл үе нь хагас жил шахам үргэлжилнэ. Үржлийн үе 2 настайгаас эхэлнэ. Байгалийн нөхцөлд 12-18 жил насална.

Habits and breeding: Lives in herds with 3-40 individuals on high mountains. Herds become larger in autumn and winter. Active in the morning and evening, grazes in winter throughout the day. Feeds on different plant species. Favorite food is onions, leaves of shrubs. Mates in late November and early December. Gestation period 140-175 days. Produces one young, occasionally twins late April. Sexually mature from age 2 years. Life span 12-18 years.

Амьдрах орчин Өндөр уулсын цавчим хадтай газарт байршин амьдардаг ба улирлаар нутаг сэлгэдэг. ГИДЦГ-ын “Б” хэсгийн Хөвчийн нуруу, Өвөр хад, Тахийн шар нуруу, Тахийн Хөх өндөр, Хавтаг, Байтагийн уулс, Алагхайрхан уулын БНГ янгиртай.

Habitat: Rocky canyons of high mountains. Migrates seasonally. Found in Khovchiin nruuu, Uvur khad, Takhiin shar nruuu, Takhiin huh undur, Khavtag, Baitag mountains of Great Gobi B Strictly Protected Area and Alaghairkhan Mountain Nature Reserve.

ГОВИЙН ШИЛҮҮС

Eurasian Lynx



Таних шинж Мөч урт зэгзгэр, тавхай болон биеийн хэмжээ томтой, муурны төрөлд багтана. Зүс саарал, ухаагаас шаравтар толботой. Чихний үзүүрт 4-7 см урт шовх хар цацаг үстэй. Сүүл богино үзүүр нь хар. Биеийн урт 73-106 см, сүүлний урт

Lynx Lynx

Linnaeus, 1758

Ангилал зүй / Taxonomy

Хүрээ: Хөвчтөн / Phylum: Chordata

Анги: Хөхтөн / Class: Mammalia

Баг: Mach идэштэн / Order: Carnivora

Овог: Мийн / Family: Felidae

Төрөл: Шилүүс / Genus: Lynx

Characteristics: Large cat with long legs and big feet. Grey to tan fur with black spots. Ear tips have long black tufts of 4-7 cm length. Tail is short and black tipped. Body length 73-106 cm, tail 10-24 cm, ear 7.5-9.9 cm. Body weight 14-25 kg. Has long hair along the cheeks forming a beard. Condyle-basal length 108-150 mm.

10-24 см, чихний урт 7.5- 9.9 см. Биеийн жин 14-25 см. Шанаанаас унжсан “хууз” маягийн урт үстэй. Толгойн ясны кондилобазаль урт 108-150 мм.

Статус Засгийн газрын тогтоол – Ховор амьтан, Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – Анхааралд өртөхөөргүй зүйл.

Status: Government resolution - Rare animal, IUCN Red List – Least Concern (LC).

Амьдралын онцлог Шилүүс гол төлөв бүрэнхий, шөнийн идэвхтэй. Ганц нэгээр амьдарна. Шилүүс туулай, чандага, бор гөрөөс, хүдэр, хар сүүлтий, янгирын ишиг болон дунд биетэй шувуудаар хооллоно. Тэд уулсын хад чулууны ангал, завсар, говь талд нүх, заг, бутны номөр бараадна. Ороо нийллэг хавар 3, 4-р сард болно. Эм шилүүс 2-3 ногуул төрүүлнэ. Байгальд 15 жил хүртэл насална.

Habits and breeding: Crepuscular and nocturnal, solitary. Feeds on medium sized mammals, such as young or smaller ungulates species, hares and mid-sized birds. Dens in long hollow, base of trees or among rocks. Mates in March-April. Produces a litter of 2-3 young once a year. Life span up to 15 years.

Амьдрах орчин Шилүүс Монгол орны хойд хэсэгт холимог ой, ойт хээр, хээрийн хад чулуут бэсрэг уулс, өндөр уулархаг нутаг, говь, цөлийн хадат уулсаар тохиолдоно. ГИДЦГ-ын “Б” хэсэгт Банзайн хүрэн, Тахь ус, Хонь ус, Сэрвэн, Нүхэнгийн өвөрт тааралдана.

Habitat: Mixed forest and forest steppe in the north, high mountains, rocky hills in south and south western Gobi desert regions. Can be found in Banzain khuren, Takhi us, Khoni us, Serven and Nukhen of Great Gobi B Strictly Protected Area.